

БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ХӨВСГӨЛ САЛБАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшиний гүйэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Мөрөн хот  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 70383793 Цахим хаяг: [erdenebaatar@audit.gov.mn](mailto:erdenebaatar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг  
Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimeg@audit.gov.mn](mailto:erdenechimeg@audit.gov.mn)

Аудитор: Ч.Мөнхбаяр  
Утас: 99996784 Цахим хаяг: [mm.bayar0711@gmail.com](mailto:mm.bayar0711@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.17 № 01/266  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ МӨРӨН  
НИСЭХ БУУДЛЫН ДАРГА  
Д.ХИШИГБАТ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Тус байгууллага нь 2021 онд орлогыг 24.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай холбоотойгоор орон нутгийн нислэг 90 хувиар буурч, орлого 12,9 сая төгрөгөөр тасарсан байна. Аудитын дүгнэлтийг зөвхөн зорилтот хэрэглэгч нарт зориулан бэлтгэсэн болно.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад асуудал**

Аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой, нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн асуудал байхгүй, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээлэл байхгүй болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	18,376,835.65	44,949.24
1.1.2	Дансны авлага	7,005,825.65	6,645,834.90
1.1.6	Бараа материал	253,557,980.09	314,199,866.25
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>278,940,641.39</b>	<b>320,890,650.39</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,439,833,575.46	5,153,201,778.96
1.2.2	Биет бус хөрөнгө	11,818,583,788.59	11,817,973,201.08
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	58,860,435.70	62,966,360.28
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>17,317,277,799.75</b>	<b>17,034,141,340.32</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,596,218,441.14</b>	<b>17,355,031,990.71</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>2.1.</b>	<b>Өр төлбөр</b>	<b>0</b>	<b>0</b>
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,093,755.00	0
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>9,093,755.00</b>	<b>0</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>9,093,755.00</b>	<b>0</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>12,893,635,588.04</b>	<b>12,893,635,588.04</b>
2.3.1	Өмч: - төрийн	11,813,390,700.00	11,813,390,700.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,080,244,888.04	1,080,244,888.04
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,693,489,098.10	4,461,396,402.67
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17,587,124,686.14</b>	<b>17,355,031,990.71</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>17,596,218,441.14</b>	<b>17,355,031,990.71</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,128,507,286.81	1,841,604,739.82
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,062,120,717.02	1,991,648,942.17
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>1,066,386,569.79</b>	<b>-150,044,202.35</b>
4	Бусад орлого	0.00	0.00
5	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
6	Ерөнхий ба удирдлагын зардал	44,860,263.50	82,048,493.09
7	Санхүүгийн зардал	0.00	0.00
8	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
<b>9</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,021,526,306.29</b>	<b>-232,092,695.44</b>
10	Орлогын татварын зардал		
<b>11</b>	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
12	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
<b>13</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>1,021,526,306.29</b>	<b>-232,092,695.44</b>
<b>14</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>-1,021,526,306.29</b>	<b>-232,092,695.44</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,893,635,588.04	3,671,962,791.82		16,565,598,379.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>12,893,635,588.04</b>	<b>3,671,962,791.82</b>	<b>0.00</b>	16,565,598,379.86
Тайлант үеийн үр дүн		1,021,526,306.29		1,021,526,306.29
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,893,635,588.04	0.00	0.00	12,893,635,588.04
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,893,635,588.04	4,693,489,098.11	0.00	17,587,124,686.15
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,893,635,588.04	4,693,489,098.11	0.00	17,587,124,686.15
Тайлант үеийн үр дүн		-232,092,695.44		-232,092,695.44
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,893,635,588.04	4,461,396,402.67	0.00	17,355,031,990.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,858,732,799.36</b>	<b>1,549,070,666.99</b>
120009	Бусад орлого	1,713,680.98	24,545,137.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	9,430,482.38	215,529.99
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,837,681,542.00	1,524,310,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,716,074,135.36</b>	<b>1,543,471,553.40</b>
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	814,806,172.61	814,806,172.61
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	267,465,057.09	247,622,568.83
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	92,041,795.14	44,350,027.97
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	112,602,934.00	114,535,470.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	91,714,194.00	96,775,310.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	173,150,169.48	165,330,313.21
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	77,272,436.66	62,467,771.60
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>142,658,664.00</b>	<b>5,599,113.59</b>

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>150,795,082.00</b>	<b>23,931,000.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	150,795,082.00	23,931,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(150,264,644.50)</b>	<b>(23,931,000.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(7,605,980.50)</b>	<b>(18,331,886.41)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,982,816.15	18,376,835.65
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,376,835.65	44,949.24

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны гүйцэтгэл	2021 оны		зөрүү	хувь
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,076,106.8</b>	<b>1,736,993.6</b>	<b>1,529,700.4</b>	<b>207,293.2</b>	<b>88.1</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,606,256.9</b>	<b>1,723,920.9</b>	<b>1,514,043.3</b>	<b>209,877.6</b>	<b>87.8</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,069,495.4</b>	<b>1,092,150.0</b>	<b>949,619.1</b>	<b>142,530.9</b>	<b>86.9</b>
Үндсэн ба нэмэгдэл цалин	928,270.4	943,155.0	821,579.1	121,575.9	87.1
Унаа хоолны хөнгөлөлт	141,225.0	148,995.0	128,040.0	20,955.0	85.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>144,757.8</b>	<b>152,901.0</b>	<b>134,294.3</b>	<b>18,606.7</b>	<b>87.8</b>
Тэтгэврийн даатгал	91,624.7	98,293.4	86,778.4	11,515.0	88.3
Тэтгэмжийн даатгал	10,779.4	10,921.5	9,628.9	1,292.6	88.2
ҮОМШ-ийн даатгал	19,327.3	19,658.6	17,203.6	2,455.0	87.5
Ажилгүйдлийн даатгал	2,093.3	2,184.2	1,880.3	303.9	86.1
Эрүүл мэндийн даатгал	20,933.1	21,843.2	18,803.1	3,040.1	86.1
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>100,254.0</b>	<b>117,232.0</b>	<b>68,701.5</b>	<b>48,530.5</b>	<b>58.6</b>
Гэрэл, цахилгаан	76,912.1	77,509.0	38,877.5	38,631.5	50.2
Түлш, халаалт	20,953.2	36,604.0	27,687.4	8,916.6	75.6
Цэвэр, бохир ус	2,388.7	3,119.0	2,136.6	982.4	68.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>72,369.2</b>	<b>71,364.5</b>	<b>71,824.4</b>	<b>(459.9)</b>	<b>100.6</b>
Бичиг хэрэг	3,905.1	2,731.7	2,521.1	210.6	92.3
Тээвэр, шатахуун	52,347.0	51,601.9	53,986.7	(2,384.8)	104.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,895.8	7,058.0	7,082.4	(24.4)	100.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,291.5	7,072.0	5,903.8	1,168.2	83.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	929.8	2,900.9	2,330.4	570.5	80.3
<b>Нормативт зардал</b>	<b>10,691.5</b>	<b>11,560.8</b>	<b>9,655.8</b>	<b>1,905.0</b>	<b>83.5</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,691.5	11,560.8	9,655.8	1,905.0	83.5
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>140,958.3</b>	<b>143,461.0</b>	<b>148,636.2</b>	<b>(5,175.2)</b>	<b>103.6</b>
Багаж, техник, хэрэгсэл	130,021.8	92,551.0	105,594.3	(13,043.3)	114.1

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Барилга	30,702.6	29,422.0	25,025.7	4,396.3	85.1
Тоног төхөөрөмжийн	36,285.4	15,624.0	19,173.1	(3,549.1)	122.7
Автомашин	15,542.6	36,030.0	51,396.2	(15,366.2)	142.6
Аэродром	38,122.2	11,475.0	9,999.3	1,475.7	87.1
Гал унтраах зардал	9,369.0	15,500.0	12,272.9	3,227.1	79.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,936.5	35,410.0	30,769.0	4,641.0	86.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>30,269.2</b>	<b>23,819.2</b>	<b>14,376.3</b>	<b>9,442.9</b>	<b>60.4</b>
Дотоод албан томилолт	30,269.2	23,819.2	14,376.3	9,442.9	60.4
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,461.5</b>	<b>107,267.5</b>	<b>113,815.8</b>	<b>(6,548.3)</b>	<b>106.1</b>
Харуул хамгаалалтын зардал	2,100.1	2,100.0	1,420.0	680.0	67.6
Үл хөдлөх хөрөнгийн татвар	13,550.3	65,641.5	74,036.5	(8,395.0)	112.8
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	136.1	3,642.0	2,897.2	744.8	79.5
Даатгалын үйлчилгээ	-	21,124.0	20,786.2	337.8	98.4
Тээврийн хэрэгслийн татвар	1,907.3	655.0	452.0	203.0	69.0
Газрын төлбөр	13,008.3	13,865.0	14,097.0	(232.0)	101.7
Банк санхүүгийн үйлчилгээний төлбөр	-	240.0	126.9	113.1	52.9
Холбооны суваг ашигласны хөлс	-	4,165.0	654.6	3,510.4	15.7
Үл хөдлөх хөрөнгийн татвар	74,524.0	1,275.0	654.6	620.4	51.3
Дотоод сургалт	246.9	2,890.0	2,465.3	424.7	85.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	600.0	10,850.0	13,437.1	(2,587.1)	123.8
Эмчилгээний төлбөр	-	2,222.7	2,220.0	2.7	99.9
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>30,621.6</b>	<b>24,900.0</b>	<b>11,901.4</b>	<b>12,998.6</b>	<b>47.8</b>
Буулт, хөөрөлтийн орлого	6,800.5	8,000.0	2,236.7	5,763.3	28.0
Зорчигч үйлчилгээний орлого	2,392.0	4,000.0	216.1	3,783.9	5.4
<b>Бусад орлого</b>	<b>21,429.1</b>	<b>12,900.0</b>	<b>9,448.6</b>	<b>3,451.4</b>	<b>73.2</b>
<b>Санхүүжилтийн дүн /ИНҮТ/</b>	<b>1,897,441.80</b>	<b>1,712,093.6</b>	<b>1,524,310.0</b>	<b>187,783.6</b>	
<b>орон тоо</b>	<b>39</b>	<b>40</b>	<b>39</b>	<b>1</b>	

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэр агаарын зайд эдийн засгийн үр ашигтай агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, удирдан чиглүүлэх, зохион байгуулалтаар хангахад оршино. ИНҮТ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нисэх буудлын үйлчилгээ, аэродромын үйлчилгээ, зорчигч үйлчилгээ, аюулгүй байдлын үйлчилгээ, хамгаалалтын үйлчилгээ, шатахууны хангамж, хадгалалтын үйлчилгээ, ачаа, шуудангийн үйлчилгээ, газрын тусгай үйлчилгээ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит аж ахуйн тооцооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувийг Иргэний нисэхийн үндэсний төв эзэмшиж байна.

### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудал нь Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны А/443 дугаар тушаалыг үндэслэн байгуулсан байна. Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/69 дүгээр тушаалаар "Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрэм"-ийг баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;" гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна. Энэ хүрээнд ИНЕГ-ын харьяа Иргэний нисэхийн үндэсний төв үйлдвэрийн газар байгуулж аймгуудын нисэх буудлуудыг түүний салбар болгон ажиллуулах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог нэгээр бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ИНЕГ-ын даргын тушаалаар тогтоосон байна.

Илүү цагийг олгохгүй байх үүднээс ээлжийн ажилчдын хуваарьт өөрчлөлт оруулж өдрийн ажилчдыг зарим өдөр зохицуулалт хийж зайнаас ажиллуулах зарчмаар ажиллуусны үр дүнд жилийн цалингийн сангаас нийт 142.5 сая төгрөг хэмнэсэн байна. Цалин хөлс, нийгмийн даатгалын зардлаас бусад зардлыг 10-аас доошгүй хувиар хэмнэлт гаргаж бичиг хэрэг 0.2 сая, нормын хувцас 1.9 сая, засварын зардал 4.6 сая, томилолтын зардал 9.4 сая, түлш халаалтын зардал 8.9 сая, гэрэл цахилгааны зардал 38.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж, тэтгэмж шагнал урамшууллын зардлыг гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын санхүүгийн тайлангууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,376.8	44.9	-18,331.9
Авлага	7,005.8	6,654.8	-351.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	58,860.4	62,966.4	4,106.0
Бараа материал	253,557.9	314,199.9	60,642.0
Үндсэн хөрөнгө	5,439,833.6	5,153,201.8	-286,631.8
Биет бус хөрөнгө	11,818,583.8	11,817,973.2	-610.6
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>17,596,218.4</b>	<b>17,355,031.9</b>	<b>-241,186.5</b>
Богино хугацаат өглөг	9,093.7		-9,093.7
Эздийн өмч	17,587,124.7	17,355,031.9	-232,092.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>17,596,218.4</b>	<b>17,355,031.9</b>	<b>-241,186.5</b>

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 0,04 сая төгрөг байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд үүссэн дотоодын авиа компаниудаас авах авлага 0.4 сая төгрөгөөр хасагдсан нь авлагын бууралтад голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 6.6 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 314.2 сая төгрөг болж 60.6 сая төгрөгөөр өссөн нь шатахууны нөөц 46.4 сая төгрөг, нүүрсний үлдэгдэл 6.4 сая төгрөг, засварын материал 7.2 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Оны эцэст 82.0 сая төгрөгийн онгоцны ТС-1 түлш худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь шатахууны үнэ нэмэгдэх магадлалтайгаас нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд: шинээр 217.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсанаар нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 325 дугаар тогтоолоор нийт 160.5 сая төгрөгийн өртөгтэй, 79 ширхэг хөрөнгийг акталж, 0.3 сая төгрөгийн хөрөнгийн ангилал хооронд залруулсан байна

#### 3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу ИНҮТ-ийн дарга байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ИНҮТ-ийн даргын 2021 оны 07 дугаар тушаалаар Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 24.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,738.8 сая төгрөгөөр, 219.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. ИНҮТ-ийн даргын 2021 оны 253 дугаар тушаалаар Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1,737.0 сая төгрөгөөр буюу 1.8 сая төгрөгөөр хасах тодотгол хийгдсэн байна.

Гүйцэтгэлээр 11.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,529.7 сая төгрөгийн зардал гарган, 1,517.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 11.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 13.0 сая төгрөг буюу 52.2 хувиар тасарсан нь ковид-19 цар тахлын нөлөөнөөс нислэгийн тоо 90 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,529.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 207.3 сая төгрөг буюу 11.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж төсвийн хэмнэлт гарган ажилласан нь гол нөлөө үзүүлсэн байна.

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлагын данс, хөрөнгө бүртгэлд тусгаж авах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон аудит ХХК-ийн захирал Л.Отгонбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланг Бизкон аудит компанийн Хөвсгөл аймаг дахь салбарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Дотоод хяналт**

ИНҮТ-ийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 15/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалт хийсэн байна. Ажлын хэрэгцээнд олгогдсон бараа материалын шаардах хуудсыг тухай бүр бичиж холбогдох зардлын дансанд гүйлгээг хийдэггүйгээс бараа материалын биет үлдэгдэл нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй байна. Бараа материалыг бүртгэлд тусгахдаа хэмжих нэгж, тоо ширхэг болон барааны бүлгийг буруу сонгодог зөрчил давтагдан гарсаар байна. Шилэн дансны мэдээллийг буруу, дутуу мэдээлж байсан дутагдлаа 2021 онд залруулан ажиллаж байна, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо тушаалд зааснаар гүйцэтгэлийн үр дүнг харгалзаж олгодоггүй гэж тус тус дүгнээд 13 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудал нь 2018 онд MNS ISO9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэгжүүлж ажиллахаар СХЗГ-ын бүртгэлийн 147 дугаар гэрчилгээ авч байсан бол 2021 оныг “Олон улсын нэгдсэн тогтолцоо (чанар, аюулгүй

ажиллагаа, ХАБЭА)-г хэрэгжүүлэх жил болгон зарлаж менежментийн тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны цэвэр хөрөнгө 17,587.0 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 61.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудал нь тайлант онд нийт 112.4 сая төгрөгийн 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээллийг ил тод байршуулж, хугацаа болоогүй нэг мэдээлэл байна, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил байхгүй байна.

##### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын заалттай нийцсэн,

ТБОНӨХБАУХА тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь хуулийн шаардлагад нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 6.Завсрын аудитын дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснөөс зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	1		1				

#### 7.Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн болон 46.2 сая төгрөгийн авлага , хөрөнгө бүртгэлд тусгах алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 46.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 61.5 сая төгрөгийн түвшинээс 15.3 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 8.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

##### 8.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт байхгүй болно.

##### 8.3 Албан шаардлага

Албан шаардлага тогтоогоогүй

##### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Авлагын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг хянаж үзэхэд оны эхэнд байсан Аэро Монголиа ХХК-иас авах 2.0 сая төгрөг, Хүннү Эйр ХХК-иас авах авлага 4.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 6 дугаар

зүйлийн 6.4.4 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Эдгээр хоёр байгууллагаас авах авлагыг барагдуулах талаар бодитой санаачлага гарган ажиллах.

**2. Хөрөнгийн данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:**

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын багцаас зорчигч хүлээн авах танхимын засварыг 39.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн 2021 оны 12 дугаар сарын 03-нд хүлээлгэн өгсөн боловч холбогдох зөвшөөрөл ирээгүй шалтгаанаар барилгын үнэнд капиталжуулж бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; гэсэн заалттай болон нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Энэ засварын ажлыг 2022 оны эхний хагас жилийн тайланд тусгаж үндсэн хөрөнгийн дүнд нэмэгдүүлж бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

  
Огноо

Б.ТЭГШДЭЛГЭР/

3.18


АХЛАХ АУДИТОР

  
Огноо

Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

3.18


БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

  
Огноо

/Л.ОТГОНБАЯР/

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АУДИТОР

  
Огноо:

Ч.МӨНХБАЯР/

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Байгууллагын д/д нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт зөрчлийн дүн		Үүнээс Запуулга		Акт	Албан шаардлага		Хариудлага тооцоо		Зөвлөмж			
				Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
				/Мянган төгрөгөөр/												
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Мөрөн нисэх буудал ХӨА-2022/01/НА-СТА-ТӨА	Засаарын ажлыг данскилийн тайланд тусгаж бүртгэлд тусгаж аваагүй	Энэ засаарын ажлыг 2022 оны эхний хагас данскилийн тайланд тусгаж үндсэн хөрөнгийн дүнд нэмэгдүүлж бүртгэх.	1	39,600.0								1	39,600.0		
2	Мөрөн нисэх буудал ХӨА-2022/01/НА-СТА-ТӨА	Харилцагч байгууллагаас авах авлагыг аваагүй	Авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах	1	6,645.8								1	6,645.8		
<b>ДҮН</b>				2	46,245.8								2	46,245.5		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
ДҮН																
НИЙТ ДҮН																